

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/59/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
1. Аудитын гэрчилгээ	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Албан шаардлага.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/193
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН
ЗДТГ-ЫН ДАРГА Н.УРАНЦЭЦЭГ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нотруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянцогт сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022-НА-СТА-ТШЗ 19020592

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,890,117.26	26,057,308.12
35	БАРАА МАТЕРИАЛ	23,790,117.26	25,232,308.12
351	Түүхий эд материал	2,659,018.12	5,443,118.12
35410	Бичиг хэргийн материал	692,200.00	825,600.00
35420	Аж ахуйн материал	12,568,899.14	10,313,590.00
35470	Бусад хангамжийн материал	7,750,000.00	8,530,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	1,100,000.00	825,000.00
36600	Бусад нөөц	1,100,000.00	825,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,254,481,435.97	1,253,344,982.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,254,481,435.97	1,253,344,982.29
392	Биет хөрөнгө	1,213,085,195.97	1,211,990,772.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,151,013,371.82	1,151,229,307.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(178,040,691.05)	(236,409,766.21)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	92,510,000.00	117,250,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(89,810,000.00)	(91,084,000.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	120,128,293.06	101,546,433.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(77,436,869.16)	(46,031,838.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	100,650,619.02	117,754,140.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,861,669.56)	(23,115,885.23)
39209	Зам, гүүрийн байгууламж	145,535,664.00	145,535,664.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(16,904,522.16)	(25,356,783.24)
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,400,000.00	31,400,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(31,400,000.00)	(31,400,000.00)
39217	Ном	301,000.00	673,500.00
393	Биет бус хөрөнгө	41,396,240.00	41,354,210.00
39301	Програм хангамж	420,300.00	420,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(84,060.00)	(126,090.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	41,060,000.00	41,060,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	1,279,371,553.23	1,279,402,290.41
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,279,371,553.23	1,279,402,290.41
51	Засгийн газрын хувь оролцоо	1,279,371,553.23	1,279,402,290.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	578,921,887.36	578,921,887.36
51101	Өмч: - төрийн	578,921,887.36	578,921,887.36
512	Хуримтлагдсан үр дүн	379,745,015.26	380,903,386.99
51210	Өмнөх үеийн үр дүн	379,745,015.26	380,872,649.81
51220	Тайлант үеийн үр дүн	-	30,737.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	442,517,206.85	586,371,241.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	56,211,374.00	87,161,075.00
120	Нийтлэг татварын бус орлого	56,211,374.00	87,161,075.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	56,211,374.00	87,161,075.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	56,211,374.00	87,161,075.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	386,305,832.85	499,210,166.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,612,332.85	97,005,466.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	5,226,140.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,297,927.85	73,331,831.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,814,405.00	18,447,495.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	348,693,500.00	402,204,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	348,693,500.00	402,204,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	469,387,686.20	583,352,731.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	463,441,486.20	571,440,231.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	437,801,311.02	527,263,496.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,426,749.70	220,959,442.71
210101	Үндсэн цалин	226,417,437.70	154,327,284.55
210102	Нэмэгдэл	-	37,143,392.80
210105	Гэрээт ажлын хөлс	3,009,312.00	29,488,765.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,466,244.97	29,305,359.89
210201	Тэтгэврийн даатгал	20,542,120.13	20,493,177.04
210202	Тэтгэмжийн даатгал	2,252,346.97	2,225,052.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,801,876.78	1,779,982.66
210204	Ажилгүйдлийн даатгал	442,718.64	436,658.56
210205	Эрүүл мэндийн даатгал	4,427,182.45	4,370,489.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,719,487.44	73,731,208.00
210301	Гэрэл, цахилгаан	6,251,102.00	7,077,234.00
210302	Түлш, халаалт	25,296,585.44	66,515,974.00
210303	Цэвэр, бохир ус	171,800.00	138,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,974,669.00	18,896,692.00
210401	Бичиг хэрэг	2,808,950.00	1,837,100.00
210402	Тээвэр, шатахуун	12,972,010.00	12,148,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,531,508.00	1,479,712.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	863,600.00
210408	Бараа материал акталсны зардал	662,201.00	2,567,550.00
2105	Нормативт зардал	886,909.14	270,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	886,909.14	270,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	936,000.00	6,414,500.00
210604	Урсгал засвар	936,000.00	6,414,500.00
2107	Томилолт, зочны зардал	4,076,500.00	1,729,500.00

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	4,076,500.00	1,729,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,480,719.00	31,591,844.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,172,114.00	30,541,275.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	230,000.00	130,579.20
210804	Тээврийн хэрэгслийн татвар	547,605.00	387,990.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,834,031.77	144,364,249.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,377,170.00	51,027,193.14
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	-	40,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	88,456,861.77	93,297,056.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,640,175.18	44,176,735.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,326,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,326,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,314,175.18	43,676,735.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,314,175.18	43,676,735.57
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,946,200.00	11,912,499.63
2200	Дотоод эх үүсвэрээр	5,946,200.00	11,912,499.63
223001	Бусад хөрөнгө	5,946,200.00	11,912,499.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(26,870,479.35)	3,018,509.56
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	78,000.00	2,987,772.38
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	78,000.00	187,132.38
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	2,800,640.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(78,000.00)	(2,987,772.38)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(26,948,479.35)	30,737.18

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	386,305,832.85	499,210,166.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	386,305,832.85	499,210,166.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,612,332.85	97,005,466.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	5,226,140.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,297,927.85	73,331,831.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,814,405.00	18,447,495.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	348,693,500.00	402,204,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	348,693,500.00	402,204,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	370,524,432.85	479,275,356.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	370,524,432.85	479,275,356.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344,884,257.67	435,098,620.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,437,889.41	220,959,442.71
210101	Үндсэн цалин	156,321,100.00	154,327,284.55
210102	Нэмэгдэл	39,498,300.00	37,143,392.80
210105	Гэрээт ажлын хөлс	33,618,489.41	29,488,765.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,431,335.26	29,305,359.89
210201	Тэтгэврийн даатгал	20,292,635.26	20,493,177.03
210202	Тэтгэмжийн даатгал	2,285,200.00	2,225,052.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,827,600.00	1,779,982.67
210204	Ажилгүйдлийн даатгал	456,600.00	436,658.56
210205	Эрүүл мэндийн даатгал	4,569,300.00	4,370,489.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,260,606.00	73,731,208.00
210301	Гэрэл, цахилгаан	6,251,102.00	7,077,234.00
210302	Түлш, халаалт	21,837,704.00	66,515,974.00
210303	Цэвэр, бохир ус	171,800.00	138,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,614,708.00	16,879,542.00
210401	Бичиг хэрэг	3,180,950.00	2,387,500.00
210402	Тээвэр, шатахуун	12,902,250.00	12,148,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,531,508.00	1,479,712.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	863,600.00
2105	Нормативт зардал	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	6,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	6,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,076,500.00	1,729,500.00
210702	Дотоод албан томилолт	4,076,500.00	1,729,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,620,079.00	31,591,844.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,311,474.00	30,541,275.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	230,000.00	130,579.20
210804	Тээврийн хэрэгслийн татвар	547,605.00	387,990.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,843,140.00	53,801,724.00

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,843,140.00	53,697,724.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,640,175.18	44,176,735.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,326,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,326,000.00	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,314,175.18	43,676,735.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,314,175.18	43,676,735.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,781,400.00	19,934,809.63
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,781,400.00	19,934,809.63
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,781,400.00	19,934,809.63
2200	Дотоод эх үүсвэрээр	15,781,400.00	19,934,809.63
223001	Бусад хөрөнгө	15,781,400.00	19,934,809.63
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(15,781,400.00)	(19,934,809.63)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	578,921,887.36	320,704,650.61	379,745,015.26	1,279,371,553.23
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	578,921,887.36	320,704,650.61	379,745,015.26	1,279,371,553.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,127,634.55	1,127,634.55
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	578,921,887.36	320,704,650.61	380,872,649.81	1,280,499,187.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,127,634.55	00.00	-1,127,634.55
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	30,737.18	30,737.18
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	578,921,887.36	319,577,016.06	380,903,386.99	1,279,402,290.41

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	382,204,600.00	351,064,941.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	382,204,600.00	351,064,941.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	382,204,600.00	351,064,941.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,001,800.00	220,959,442.71
210101	Үндсэн цалин	156,321,100.00	154,327,284.55
210102	Нэмэгдэл	39,498,300.00	37,143,392.80
210105	Гэрээт ажлын хөлс	39,182,400.00	29,488,765.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,725,200.00	29,305,359.89
210201	Тэтгэврийн даатгал	22,325,200.00	20,493,177.03
210202	Тэтгэмжийн даатгал	2,350,000.00	2,225,052.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,880,100.00	1,779,982.67
210204	Ажилгүйдлийн даатгал	470,000.00	436,658.56
210205	Эрүүл мэндийн даатгал	4,699,900.00	4,370,489.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,854,900.00	53,074,794.00
210301	Гэрэл, цахилгаан	5,230,500.00	4,812,394.00
210302	Түлш, халаалт	48,124,400.00	48,124,400.00
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	138,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,403,900.00	12,701,252.00
210401	Бичиг хэрэг	2,352,500.00	2,352,500.00
210402	Тээвэр, шатахуун	8,215,400.00	8,005,440.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,536,000.00	1,479,712.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,300,000.00	863,600.00
2105	Нормативт зардал	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,978,300.00	1,729,500.00
210702	Дотоод албан томилолт	4,978,300.00	1,729,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,327,000.00	1,050,569.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	230,000.00	130,579.20
210804	Тээврийн хэрэгслийн татвар	565,000.00	387,990.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,813,500.00	30,144,024.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,813,500.00	30,144,024.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,000,000.00	19,934,809.63
2200	Дотоод эх үүсвэрээр	20,000,000.00	19,934,809.63
223001	Бусад хөрөнгө	20,000,000.00	19,934,809.63
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	402,204,600.00	370,999,751.43
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	402,204,600.00	370,999,751.43
132001	Орон нутгийн төсвөөс	402,204,600.00	370,999,751.43
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	5.00	5.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	84,533,679.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,193,864.00	84,533,679.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,793,864.00	84,033,679.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	20,656,414.00
210301	Гэрэл, пахилгаан	-	2,264,840.00
210302	Түлш, халаалт	-	18,391,574.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,086,600.00	4,178,290.00
210401	Бичиг хэрэг	26,950.00	35,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,059,650.00	4,143,290.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,000,000.00
210604	Урсгал засвар	-	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху	4,614,124.00	30,541,275.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчил	4,614,124.00	30,541,275.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,093,140.00	23,657,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,093,140.00	23,553,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,400,000.00	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,400,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,400,000.00	500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	30,193,864.00	84,533,679.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,193,864.00	84,533,679.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс а	-	5,226,140.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдса	20,228,204.00	66,449,709.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны ху	9,965,660.00	12,857,830.00
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцогт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баянцогт сумын ЗДТГ нь сумын ИТХ, Засаг даргын бодлого боловсруулж, шийдвэр гаргахад нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин бүрдүүлэх, оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Баянцогт сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,
- Нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг шинээр боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ЗДТГ-ын даргын 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн № А/12 тоот тушаалаар зөвлөлийг 3 гишүүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан. Дотоод хяналтын ажлын хэсгийн мөрдөж ажиллах журам, заавар боловсруулж батлуулаагүй байна. ЗДТГ-ын даргын тушаалаар 2021 оны дотоод хяналт шалгалт ажлын төлөвлөгөө хуваарийг баталсан. 2018 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн хамт олны хуралдаанаар байгууллагын дотоод журмыг шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна. Дотоод журам нь 11 бүлэг 88 зүйлтэй бөгөөд ёс зүйн дүрэмд шударга зарчим, ёс зүйн үнэт зүйлсийн талаар 7, 9-р бүлэг дээр тусгаж өгсөн.

Төв аймгийн Баянцогт сумын ЗДТГ-ын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцогт сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 586,371.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 8,795.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,596.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос тооцож тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 586,371.2 мянган төгрөгийн 1,5 хувиар буюу 8,795.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,596.7 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас өөрчлөлт ороогүй байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баянцогт сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг

мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд орон нутгийн төсвөөс 402,204.6 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан. Нэмэлт санхүүжилтийн дансанд 97,969.4 мянган төгрөгийн орлого орж 85,497.6 мянган төгрөгийг зарцуулж, 12,471.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд Ургамал далай ХХК 15,000.0 мянган төгрөг, ОНХС-ийн хөрөнгөөр 26,740.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлдсэнийг бүртгэж тайлагнасан байна.

Бараа материалын дансанд нийт 85,950.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авч, 84,783.2 мянган төгрөгийн бараа материалыг зарлагдсан байна

Авлага, өглөгийн талаар:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 4,559.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 4,559.3 мянган төгрөгөөр буурч үлдэгдэлгүй тайлагнагдсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харилцах данс үлдэгдэлгүй байна. Нийт хөрөнгө 30.74 мянган төгрөгөөр нэмэгдэж 1,279,402.3 мянган төгрөг болсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	23,790.12	25,232.31	1,442.19
Үндсэн хөрөнгө	1,254,481.44	1,253,344.98	(1,136.45)
Нийт хөрөнгө	1,279,371.55	1,279,402.29	30.74
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо	1,279,371.55	1,279,402.29	30.74
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,279,371.55	1,279,402.29	30.74

Бараа материалын дансны үлдэгдэл 25,232.31 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 1,442.2 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 2,784.1 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материалын үлдэгдэл 780.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын үлдэгдэл өсөхөд шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,253,344.9 мянган төгрөг болж 1,136.45 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 25,665.6.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,279,402.29 мянган төгрөг болж 30.74 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 428,314.5 мянган төгрөгөөр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 26,109.9 мянган төгрөгөөр бууруулан 402,204.6 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь хангамжийн зардал, нормативд зардал, бараа үйлчилгээний бусад зардал хасагдсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс 402,204.6 мянган төгрөгийн санхүүжилт авч үндсэн үйл ажиллагаанд 351,064.9 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 19,934.8 мянган төгрөг зарцуулж, 31,204.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд өвс тэжээлийн үнэ 12,968.7 мянган төгрөг, хандив 3,401.1 мянган төгрөг, оготно устгалын 4,000.0 мянган төгрөг, шагнал болон ЗГ-аас төлсөн усны үнэ 3,024.7 мянган төгрөг, санхүүжилт 70,509.1 мянган төгрөгийн орлого авч өвс, тэжээл, ковид-19-тэй холбоотой болон бусад зардалд 85,497.7 мянган төгрөгийг зарцуулж, 12,471.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баянцогт сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд онцлох асуудал байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Баянцогт сумын ЗДТГ нь 31,134.9 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь төсвийн хэмнэлт хэтрэлтийн 2 дугаар улирлын мэдээг байршуулаагүй, 6, 7 сарын мэдээг хугацаандаа байршуулахдаа өмнөх сарын мэдээг өөрчлөөгүй, 4,5 сарын мэдээг хугацаа хоцроож байршуулахдаа өмнөх сарын мэдээг өөрчлөөгүй. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 65733.3 мянган төгрөгийн /өссөн дүнгээр/ мэдээллийг 2, 3, 4, 7, 12-р сард байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь байршуулж байх албан шаардлага бичив.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж, бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 сарын 10-ны өдрийн №67 тоот албан бичгээр ирүүлж зөрчлийг таслан зогсоосон байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцогт сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал ковид-19-ын оношлуурын орлого, тооцоог авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 266,004.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 169,136.2 мянган төгрөгийн алдааг залруулж, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 65,733.3 мянган төгрөг, татварын Е баримттай холбоотой 31,134.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага бичив.

4.1 Залруулсан алдаа

4.1.1 Санхүүгийн тайлангийн уялдааг шалгахад 52,133.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан

нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар" -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх." гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн.

4.1.2 Зарцуулагдаагүй үлдэгдэл 43,676.7 мянган төгрөгийг төвлөрүүлэхдээ мөнгөн гүйлгээний тайлан, мөнгөн гүйлгээний журналд өөр өөр дансанд бичилт хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар" -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх." гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн.

4.1.3 Ковид-19-ийг оношлох 1,000.0 мянган төгрөгийн тестийг хоёр өөр дансанд бүртгэсэн, бараа материалын тодруулга тайланд үнэ төлбөргүй авсан хөрөнгийг 593.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, Иргэн Базарсадтай ЭМТ-д 30,000.0 мянган төгрөгөөр Toyota hiace маркын автомашин худалдан авах гэрээ байгуулж төлбөрийг шилжүүлж авлагыг хаахдаа зардал дансанд бичилт хийж хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар" -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд

аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх." гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн.

4.1.4 Ном дансны үлдэгдэл 673.5 мянган төгрөгийг сангийн яамны Е тайланд бусад үндсэн хөрөнгө дансанд, 41,060.0 мянган төгрөгийн бусад биет бус хөрөнгө /газар эзэмших эрх/-ийг ерөнхий дэвтэр болон журналд санхүүгийн байдлын тайлангийн данснаас өөр дансанд бүртгэсэн.. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8-р заалтыг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх." гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн.

4.2 Албан шаардлага

4.2.1 Харилцагч байгууллагатай хийсэн 31,134.9 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

4.2.2 Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг үнэн зөв байршуулаагүй, өмнөх сарын мэдээг өөрчлөөгүй, хугацаа хоцроож байршуулсан, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 65,733.3 мянган төгрөгийн /өссөн дүнгээр/ мэдээллийг 2, 3, 4, 7, 12-р сард байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “Аудитаар илэрсэн

зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс					
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Баянцогт сумын ЗДТГ	7	266,004.4	5	169,136.2			2	96,868.2